# Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

## Оюуны өмчийн газар

## 2018 оны тайлан

| Д/д | Үйл ажиллагаа | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Нэг дэх үе шат ( 2017 - 2019) хүрэх түвшин , үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1 | 4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | 2017 - 2022 | | Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх | Нийт 33 ХАСУМ гаргасан бөгөөд хянасан дүгнэлтийг байгууллагын веб сайтад байршуулж, олон нийтэд танилцуулж ажилласан. Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 13-ны “Засгийн газрын зарим агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” 175 дугаар тогтоолоор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг татан буулгаж Оюуны өмчийн газрыг шинээр байгуулагдсантай холбогдуулан байгууллагын веб сайтыг шинэчлэх ажил хийгдсэн.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 2 | | 5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, | 2017 - 2022 | | Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байх | Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 13-ны “Засгийн газрын зарим агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” 175 дугаар тогтоолоор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг татан буулгаж Оюуны өмчийн газрыг байгуулсан. Тус газар нь хүний нөөцийг татан буугдсан байгууллагаас бүрдүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | | | | Энд нийт давхардсан тоогоор 33 албан хаагчийн ХАСУМ хянуулж, дүгнэлтийг хүлээн авсан. 2018 оны Газрын даргын Б тушаалуудыг веб сайтад байршуулж ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан.<br><br>Хавсралт : 2 файл | |
| 3 | 4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | 1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх | 2017 - 2022 | | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг шинэчилсэн байх | Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 13-ны “Засгийн газрын зарим агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” 175 дугаар тогтоолоор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг татан буулгаж Оюуны өмчийн газрыг байгуулсан. Тус газар нь хүний нөөцийг татан буугдсан байгууллагаас бүрдүүлсэн бөгөөд албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж, веб сайтад байршуулсан.. Төрийн албаны нөөцөөс О.Амарбатыг шинээр томилсон.<br><br>Хавсралт: 1 файл | 70% |
| 4 | 4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох | 1. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс | 2017 - 2019 | | Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс | Оюуны өмчийн газарт иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажилласан. Тус газрын 2018 оны үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос санхүүжүүлж байрны | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | | | зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх | засварын болон тавилга, эд хогшил нийлүүлэх гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах үнэлгээний хороонд ажилласан бүрэлдэхүүнээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг үйлдүүлж хянаж ажилласан.<br><br>Хавсралт: 3 файл | |
| 5 | 4.1.1.9. Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | 1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох | 2017 - 2022 | 2655000 | Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байх | 1.Төрийн байгууллагуудын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулах, төсөв хөрөнгийг хэмнэх, төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор байгууллагуудад зориулсан үйл ажиллагаа, хяналт, удирдлагын нэгдсэн систем буюу онлайн програм хангамжуудын сан бүхий вэб платформ Able системийг хэрэглэхээр гэрээ байгуулж ажилласан. 2. Санхүүгийн програм хангамжийн "Санхүүгийн Тооцоолох Групп" ХХК-тай гэрээ байгуулж, санхүүгийн бүртгэлийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.<br><br>Хавсралт: 5 файл | 100% |
| 6 | 4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, | 1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах | 2017 - 2019 | | Нийтийн албаны сургалтын институтийг байгуулсан байх | Оюуны өмчийн газарт мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан 1 мэргэжилтэн ажиллаж, иргэд аж ахуйн нэгж байгууллага руу чиглэсэн болон дотоод сургалтыг зохион байгуулдаг. 2018 оны сүүлийн хагас жилийн дотоод сургалтын төлөвлөгөө | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | нийтийн албаны сургалтын институт байгуулах | | | | боловсруулж, биелэлтийг хангаж ажилласан. Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага болон бусад орны оюуны өмчийн байгууллагуудтай нягт холбоотой ажиллаж, албан хаагчдийг сургалт, семинарт оролцуулсан. Сургалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтыг чанаржуулах, тогтмолжуулах шаардлагатай байна.<br><br>Хавсралт: 3 файл | |
| 7 | | 2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах | 2017 - 2019 | | Модуль, хөтөлбөрийн дагуу сургалтыг явуулсан байх | Оюуны өмчийн газрын албан хаагчдад зориулсан 2018 оны сүүлийн хагас жилд хийх сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулсан. Дэлхийн оюуны өмчийн байгууллага болон бусад улсуудын оюуны өмчийн байгууллагаас зохион байгуулсан сургалт, хурал зөвлөгөөнд нийт давхардсан тоогоор нийт 22 албан хаагчид оролцсон.<br><br>Хавсралт: 3 файл | 100% |
| 8 | | 3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах. Үүнд: | 2018 - 2022 | | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувь буюу 36387 албан хаагчийг сургалтад хамруулсан байх | Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журам, анхаарах зүйлийн талаар мэдээлэх, танилцуулах, арга зүйн зөвлөгөө үзүүлэх ажлуудыг тухай бүр хийж хэрэгжүүлсэн. Ажилтнуудын ХАСХОМ хугацаанд нь бүрдүүлэн бүртгүүлэх боломж, мэдээллээр хангах чиглэлээр Урьдчилан мэдүүлэг бүрдүүлэх, ХАСХОМ бүрдүүлэх тухай мэдээллүүдийг Able системээр түгээж улмаар байгууллагын нийт албан хаагчдад “Авлигаас урьдчилсан сэргийлэх, ХАСХОМ мэдүүлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, холбогдох хууль, журам гарын авлагаар хангасан.<br><br>Хавсралт нийт: 4 Файл: 1 Зураг: 3 | 100% |
| 2. Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | |
| 9 | 4.1.2.1. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах | 2017 - 2018 | | Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчилсэн байх | Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын E-filing, IPOM Publish системийг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын төслийн хүрээнд хөгжүүлж, ашиглалтанд оруулсан. Энэхүү төслийн хүрээнд шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг хязгаарлагдмал хүрээнд онлайнаар мэдүүлэх боломжтой болсон ба хөгжүүлэлтийг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын тусламжтай хийдэг. Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын дотоод системийг IPAS өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд цаашид хөгжүүлэх шаардлагатай.<br><br>Хавсралт нийт : 3 Файл : 1 Зураг : 2 | 100% |
| 10 | | 2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 2018 - 2022 | | Төрийн үйлчилгээний нэгдсэн портал сайтыг боловсронгуй болгосон байх | Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын E-filing, IPOM Publish системийг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын төслийн хүрээнд хөгжүүлж, ашиглалтанд оруулсан. | 100% |
| 11 | 4.1.2.2. Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг | 2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | 2018 - 2022 | | Төрийн бус байгууллагад шилжүүлэх зөвшөөрлийг тодорхойлсон байх | Оюуны өмчийн газраас төрийн бус байгууллагад чиг үүрэг шилжүүлж ажиллаагүй. | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | | | | | | |
| 12 | 4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох | 3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх | 2018 - 2022 | | Хяналтын шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулдаг болсон байх | Фейсбүүк орчин дахь оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор оюуны өмчийн газрын дарга Э.Эрдэнэсүрэн, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг, хяналтын ахлах байцаагч Д.Бат-Эрдэнэ нар Facebook компанийн Ази, номхон далайн бүсийн төлөөлөгчийн газрын аюулгүй байдал хариуцсан менежер Micheal Yoon-той уулзаж, фейсбүүк орчинд үйлдэгдэж буй зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчлийг гаргуулахгүй байх боломжийн талаар санал солилцож, хамтран ажиллахаар болсон. Мөн тухайн жилд явуулсан хяналт шалгалтын үйл ажиллагаа болон хяналт шалгалтын үйл ажиллагааны тайланг цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлсэн. Түүнчлэн тус газраас Кабелийн сувгийн телевизийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж, зөвлөгөө анхааруулга өгч ажилласан. Нийслэлийн томоохон худалдааны төвүүдийн захиргаанд оюуны өмчийн зөрчлийг арилгах тухай албан бичгийг хүргүүлж ажилласан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 13 | 4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх | 2017 - 2022 | | ТББ, мэргэжлийн холбоо, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар 2 | Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 13-ны “Засгийн газрын зарим агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” 175 дугаар тогтоолоор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг татан буулгаж Оюуны өмчийн газар шинээр байгуулагдсан. Энэ хугацаанд хөндлөнгийн үнэлгээ хийгдээгүй. Авлигатай | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | | | | жил тутамд үнэлгээ хийлгэсэн байх | тэмцэх газраас хэрэгжүүлсэн байгууллагын шударга байдлын үнэлгээнд Оюуны өмчийн газар хамрагдсан.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 14 | | 2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх | 2018 - 2019 | | Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэд үнэлгээ өгдөг болсон байх | Оюуны өмчийн газарт 2018 онд иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулгын судалгаанаас оюуны өмчийн газрын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хандаагүй байна. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай. | 70% |
| 3. Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх | | | | | | | |
| 15 | 4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох | 1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулах | 2017 - 2019 | | Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хэвшүүлсэн байх | Оюуны өмчийн газар нь Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Засгийн газрын зарим агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” 175 дугаар тогтоолоор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг татан буулгаж байгуулагдсан. 2018 оны 07 дугаар сараас шилэн дансыг хөтөлж, олон нийтэд мэдээлж ажилласан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% |
| 16 | | 2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих | 2017 - 2020 | 200000 | Тусгай сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийн ил тод байдлын үнэлгээг хийж, холбогдох журам, дүрэмд | 1.Өөрийн орлогоор, хялбаршуулсан журмаар Тавилга, эд хогшил болон Оюуны өмчийн газрын байрны засварын тендер зарласан бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж нийтэд 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зарласан. 2.Эдийн засгийн шуудан сонинд 2 тендерийн урилгуудыг зэрэгцээ хэвлүүлж, олон нийтэд мэдээлсэн. 3.Байгууллагын вебхуудсанд тендерийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | боломжийг нээх | | | өөрчлөлт оруулсан байх | мэдээллүүдийг оруулсан.<br>Хавсралт : 2 файл | |
| 17 | 4.1.3.4. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | 1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах | 2017 - 2022 | | Орон нутгийн төсвийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх нөхцөл бүрдсэн байх | Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй. | Үнэлэх боломжгүй |
| 18 | | 2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх | 2018 - 2022 | | Цахим хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төсвийн төсөлд санал авах мэдээллийг хүргэж хэвшсэн байх | Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй. | Үнэлэх боломжгүй |
| 19 | 4.1.3.7. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах | 2. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх | 2017 - 2019 | | Журмыг батлуулж, хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлсэн байх | Энэ тохиолдол бүртгэгдээгүй байна. | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтолцоог бүрдүүлэх | | | | | |
| 6. Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх | | | | | | | |
| 20 | 4.1.6.2. Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн заагийг тодорхойлох | 1. Хувийн хэвшлийн байгууллагуудын чадавхжуулах цогц сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах | 2017 - 2019 | | Сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшүүлсэн байх | Оюуны өмчийн эрхийн хамгаалалттай холбоотой хууль, эрх зүйн мэдлэг олгох дараах сургалтуудыг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудад зохион байгуулсан. -Сити дээд сургууль дээр 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр 500 гаруй багш оюутануудад Патентийн эрхийн хамгаалалт сэдэвт сургалт, -Багануур дүүрэгт 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр "Багануур үйлдвэрлэл технологийн парк" ОНӨТҮГазрын хүсэлтээр "Шинэ санаагаа оюуны өмчөөр баталгаажуулж хөрөнгө болгоё" сэдэвт сургалт, -Химийн Хүрээлэнгээс зохион байгуулсан Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтанд “Оюуны өмчийн эрх хамгаалахад тавигдах шаардлага” сэдэвт сургалт, -“ИЗОУИС-ын Дүрслэх урлаг дизайн технологийн сургууль дээр “Шинэ бүтээл, ашигтай загвар, тавигдах шаардлага” сэдэвт сургалт, -МУИС-ын багш, оюутны стартап-2018 хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “Гарааны компанийн менежмент” сургалтанд “Гарааны компани байгуулахад оюуны өмчийн менежментийн асуудал” сэдэвт сургалт, -Оюуны өмчийг хамгаалах өдрийн хүрээнд 4.26-ны өдөр “Монгол улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн менежмент” сэдэвт үндэсний семинар, -Боловсролын яам, ШУТИС, NIRAS зөвлөх компаны хамтран зохион байгуулсан Оюуны өмчийн эрхийн хамгаалалт сэдэвт семинар, хэлэлцүүлэгт оролцож, Publish.ipom.mn-дээр хайлт хийх сургалт. -МУИС-ын Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтсээс зохион байгуулсан “Шинэ бүтээлийн хайлт” сэдэвт сургалт, --Уг дэд зорилтын хүрээнд МҮОНРТ-ийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний телевизийн "Эрхзүйн хөтөч" нэвтрүүлгийн 2 удаагийн дугаараар Оюуны өмчийн зөрчил сэдвээр мэдээлэл, -V телевизийн “Syndicate talk” нэвтрүүлэгт оролцож, Оюуны өмч, компанийн биет бус хөрөнгө гэж юу вэ, эдгээрийг бий болгохын тулд ямар их хүч хөдөлмөр, хөрөнгө оруулалт ордог тухай, оюуны өмчийг хэрхэн хамгаалж бусдыгаа хүндлэх тухай мэдээлэл, | |
| 21 | 4.1.6.4. Картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах | 4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | 2018 - 2020 | | Хөтөлбөрийг төслийг боловсруулж, батлуулсан байх | Оюуны өмчийн үндсэн гол хуулиуд болох Патентын тухай хууль болон Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хуульд шинэчилсэн найруулга, Барааны тэмдэг, Газарзүйн заалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл дээр ажиллаж байна. | Үнэлэх боломжгүй |
| 7. Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих | | | | | | | |
| 22 | 4.1.7.2. Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа, санхүүжилтийг ил тод, нээлттэй болгох чиглэлээр төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох | 2. Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, гишүүдийн мэдээлэл, хандив, орлого, зарлагыг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх механизмыг бүрдүүлэх | 2019 - 2020 | | Эрх зүйн зохицуулалт бий болгосон байх | Оюуны өмчийн газар нь  дараахь субьектэд тусгай зөвшөөрөл олгож, гэрээ байгуулж ажилладаг. 1. Патентын тухай хуулийн 7.12. Мэдүүлэг гаргагч нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно. Тус хуулийн 27 дугаар зүйл Оюуны өмчийн газар нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг баталж, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах тусгай зөвшөөрөл олгодог.  Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын төлөөллийн үйл ажиллагааны тайланг Оюуны өмчийн газарт ирүүлэх бөгөөд үйлчилгээний хөлсний 10%-ийг Оюуны өмчийн газарт өгөхөөр Патентын тухай хуульд заасан. https://www.legalinfo.mn/law/details/440?lawid=440<br>2.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухайн | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.Зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид эрхээ хамгаалуулах зорилгоор, хамтын удирдлагын байгууллагыг байгуулан ажиллуулж болно.27.4.Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахдаа оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллана гэж тус тус зааснаас гадна 29.1.1.зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчид бүтээл ашигласны шагналыг олгохдоо тухайн бүтээлийг ашигласантай холбогдолтой мэдээллийг танилцуулах үүрэгтэй. https://www.legalinfo.mn/law/details/283<br><br>Хавсралт : 1 файл | |
| 23 | 4.1.7.3. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, | 1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх | 2017 - 2019 | | Хяналт тавих боломж бүрдсэн байх | Ийм үйл ажиллагаа хийгдэж байгаагүй. | Үнэлэх боломжгүй |
| 24 | | 2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд | 2018 - 2022 | | Төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээний жагсаалтыг баталсан байх | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж ажиллаагүй. | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | мэдээлэх | | | | | |
| 10. Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх | | | | | | | |
| 25 | 4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах | 2017 - 2022 | | Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ ахисан байх | Байгууллагын нийт ажилтнуудад зориулсан авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах, авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах ажлын хүрээнд: 1. “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ыг хүргүүлсэн. 2. Албан тушаалтны мэдэгдэл, тайлбарыг холбогдох хуулийн заалтын дагуу мэдээлэх тухай, холбогдох журмыг хүргүүлсэн (2018.10.03.) 3. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор албан тушаалтан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”- ийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах тухай мэдээллийг байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан мэдээллийг ойлгомжтой хэлбэрт оруулан хүргүүлсэн. 4. Тайлангийн хугацаанд 2 тендер зарласны дагуу ажлын хэсэгт орсон албан тушаалтан болон бусад албан хаагчдад мэдээлэл өгөх зорилгоор “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” ирүүлэх тухай мэдээллийг хүргүүлсэн. 5. Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын арга шийтгэлийн талаарх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр анхаарч ажиллах чиглэлээр тус оны сахилгын шийтгэлүүдийг Able системд байршуулж, мэдээлсэн. 6. Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | журмын шинэлэг зүйлийн талаар танилцуулах, ажилтнуудын ХАСХОМ хугацаанд нь бүрдүүлэн бүртгүүлэх боломж, мэдээллээр хангах чиглэлээр Урьдчилан мэдүүлэг бүрдүүлэх, ХАСХОМ бүрдүүлэх тухай мэдээллүүдийг Able системээр түгээсэн.<br><br>Хавсралт : 1 файл | |
| 26 | 4.1.10.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | 1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх | 2017 - 2022 | | Аймаг, нийслэлд 100 сургагч багшийг бэлтгэсэн байх | Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журам, анхаарах зүйлийн талаар мэдээлэх, танилцуулах, арга зүйн зөвлөгөө үзүүлэх ажлуудыг тухай бүр хийж хэрэгжүүлсэн бөгөөд ажилтнуудын ХАСХОМ хугацаанд нь бүрдүүлэн бүртгүүлэх боломж, мэдээллээр хангах чиглэлээр Урьдчилан мэдүүлэг бүрдүүлэх, ХАСХОМ бүрдүүлэх тухай мэдээллүүдийг Able системээр түгээж улмаар байгууллагын нийт албан хаагчдад “Авлигаас урьдчилсан сэргийлэх, ХАСХОМ мэдүүлэх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, холбогдох хууль, журам гарын авлагаар хангасан.<br><br>Хавсралт нийт : 4 Файл : 1 Зураг : 3 | 100% |